

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 11.120.01

Эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2016

Drug prescription and prescribing MNS 5376: 2016-ийн оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 20..... оны дүгээр сарын-ний өдрийн дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг 20..... оны дугаар сарын-ны өдрөөс эхлэн мөрдөнө.

1.Зорилго

Эмийн жор бичилтийг мөрдүүлэх, жороор эм олголтыг хэвшүүлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмч, эмийн мэргэжилтэн, иргэний хоорондын холбоог сайжруулахад оршино.

2.Хамрах ба хэрэглэх хүрээ

Энэхүү стандартыг бүх шатлалын эрүүл мэндийн байгууллага, эмийн сан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж мөрдөх ба эмийн жор бичилт, жороор олголтыг үнэлэх, эмч болон жор баригч нарт хариуцлага тооцоход хэрэглэнэ.

3.Норматив эшлэл

Энэ стандартад эш татаж хэрэглэсэн дараах стандарт болон норматив техникийн баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ.

MNS 52..... : 20....., Эмийн санд тавих нийтлэг шаардлага

4 Нэр томъёо, тодорхойлолт

4.1

Эмийн жор

Эмчээс тухайн хэрэглэгчид зориулан эмийн нэр, тун, хэмжээ, хэрэглэх аргыг заан эм зүйч, эм найруулагчид хандсан цаасан болон цахим баримтыг

Цахим жор

“Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376:20.... стандартын 4.1 дүгээр заалтад заасан эмийн жорыг цахимаар дамжуулж буй хэлбэрийг

4.3

Цахим жорын систем

Цахим жорыг бүртгэх, хянах, хамгаалах, хадгалах, ашиглах, баяжуулах зориулалт бүхий Эрүүл мэндийн хөгжлийн төв дээр байрлах цахим системийг,

4.4

Цахим жорын системд нэвтрэх эрх

Тухайн эрүүл мэндийн байгууллагын эмч регистрийн дугаараараа цахим жорын системд нэвтэрч жор бичих эрхийг

4.5

Цахим жор бичигч

Цахим жорын системд нэвтрэх эрх авсан эмчийг

4.6

Жор баригч

Эм зүйн шинжлэх ухаан, эмийн технологийн дагуу эмийг найруулах, савлан бэлтгэх, шалгаж олгох эм барих үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй этгээдийг ойлгоно.

4.7

Хүчингүй жор

Энэхүү стандартад заасан жорын маягтад тусгагдсан мэдээллийг стандартад заасны дагуу бүрэн бичиж, баталгаажуулаагүй, хүчинтэй хугацаа дууссан болон стандартын бус маягт дээр бичсэн жорыг хэлнэ.

4.8

Индекс

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч Эрүүл мэндийн байгууллагууд мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жоронд тэмдэглэсэн тусгай тэмдэглэлийг хэлнэ

4.9

Дугаар

“Мансууруулах, “сэтгэцэд нөлөөт” эмийн жоронд тэмдэглэсэн дугаарлалтын тоог хэлнэ.

4.10

цахим жорын код

Тухайн эмийн жор бүрд цахим жорын системээс олгогдох давтагдахгүй кодыг

5 Эмийн жорын маягт, ангилал

5.1 Эмийн жорын маягтыг “энгийн”, “сэтгэцэд нөлөөт”, “мансууруулах” эмийн гэж ангилна.

5.2 Энгийн эмийн жор нь А4 цаасыг хөндлөнгөөр нь 3 хуваасны нэг (9,9 см өргөн х 21,5 см урт)-тэй тэнцүү хэмжээтэй, хэвлэмэл маягт (цаашид “маягт” гэх) байна. (А хавсралт)

5.3 Энгийн эмийн жор дараах мэдээллийг агуулна.

5.3.1 Өвчтөний овог, нэр, нас, хүйс;

5.3.2 Өвчтөний регистрийн дугаар;

5.3.3 Онош (ICD кодын хамт бүрэн бичих)

5.3.4 Эмийн нэр, тун, хэлбэр, тоо хэмжээ;

5.3.5 Эм хэрэглэх арга, хугацаа;

5.3.6 Эмчийн нэр, утас, тэмдэг;

5.3.7 Эмнэлгийн нэр;

5.3.8 Жор бичсэн огноо;

5.3.9 Жор баригчийн тэмдэглэгээ;

5.3.10 Анхааруулга болон иргэнд үлдэх хэсэг.

5.4 Сэтгэцэд нөлөөт эмийн жор маягт нь (индекс)-тай ~~хэвлэмэл дугаар~~ А4 цаасыг хөндлөнгөөр нь 3 хуваасны нэг (9,9 см өргөн х 21,5 см урт)-тэй тэнцүү хэмжээтэй маягт байх ба баруун дээд булангаас зүүн доод булан хүртэл 5 мм-ийн өргөнтэй ногоон зураастай байна (В хавсралт).

5.5 Сэтгэцэд нөлөөт эмийн жор дараах мэдээллийг агуулна.

5.5.1 Дугаар; Индекс

5.5.2 Өвчтөний овог, нэр, нас, хүйс,

5.5.3 Өвчтөний регистрийн дугаар;

5.5.4 Онош (ICD ангиллалын кодын хамт бүрэн бичих)

5.5.5 Эмийн нэр, тун, хэлбэр, тоо хэмжээ;

5.5.6 Эм хэрэглэх арга, эмчилгээний хугацаа;

5.5.7 Эмчийн нэр, утас, тэмдэг;

5.5.8 Ерөнхий эмчийн гарын үсэг;

5.5.9 Эмнэлгийн нэр, тэмдэг;

5.5.10 Жор бичсэн огноо;

5.5.11 Эм хүлээн авсан хүний нэр, регистрийн дугаар;

- 5.5.12 Утасны дугаар;
- 5.5.13 Гарын үсэг;
- 5.5.14 Эм олгосон огноо;
- 5.5.15 Жор баригчийн тэмдэглэгээ;
- 5.5.16 Анхааруулга болон иргэнд үлдэх хэсэг.

Цахим жор нь индексийг оруулсан

5.6 Энгийн эмийн жорын маягтыг тухайн эрүүл мэндийн байгууллага энэхүү стандартад заасан загварын дагуу хэвлүүлж, эмч мэргэжилтнүүдэд түгээнэ.

5.7 Сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтыг улсын нэгдсэн дугаартайгаар аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар стандартад заасан загварын дагуу хэвлүүлж, дугаарлаж, эрүүл мэндийн байгууллагуудад түгээнэ.

5.8 Мансууруулах эмийн жорын маягт нь улсын нэгдсэн дугаар хэвлэмэл дугаар (индекс)-тай, А4 цаасыг хөндлөнгөөр нь 3 хуваасны нэг (9,9 см өргөн х 21,5 см урт)-тэй тэнцүү хэмжээтэй, маягт байх ба баруун дээд булангаас зүүн доод булан хүртэл 5 мм-ийн өргөнтэй, шар зураастай байна. (С хавсралт)

5.9 Мансууруулах эмийн жор дараах мэдээллийг агуулна.

- 5.9.1 **Дугаар**; индекс;
- 5.9.2 Өвчтөний овог, нэр, нас, хүйс,
- 5.9.3 Өвчтөний регистрийн дугаар;
- 5.9.4 Онош; (ICD ангиллалын кодын хамт бүрэн бичих)
- 5.9.5 Эмийн нэр, тун, хэлбэр, тоо хэмжээ;
- 5.9.6 Эм хэрэглэх арга, эмчилгээний хугацаа;
- 5.9.7 Эмчийн нэр, утас, тэмдэг;
- 5.9.8 Ерөнхий эмчийн гарын үсэг;
- 5.9.9 Эмнэлгийн нэр; тэмдэг;
- 5.9.10 Жор бичсэн огноо;
- 5.9.11 Эм хүлээн авсан хүний нэр, регистрийн дугаар;
- 5.9.12 Утасны дугаар;
- 5.9.13 Гарын үсэг;
- 5.9.14 Эм олгосон огноо;

5.9.15 Жор баригчийн тэмдэглэгээ;

5.9.16 Анхааруулга болон иргэнд үлдэх хэсэг.

5.10 Мансууруулах эмийн жорын маягтыг улсын нэгдсэн дугаар (индекс)-тайгаар аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар стандартад заасан загварын дагуу цаас хэлбэрээр хэвлүүлж эрүүл мэндийн байгууллагуудад түгээнэ.

6 Эмийн жор бичих

~~6.1 Эмчлэх эрх бүхий хүний их эмч энгийн, сэтгэцэд нөлөөт, мансууруулах болон эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй, бага эмч энгийн эмийн жорыг өвчтөний оношийн дагуу энэхүү стандартыг баримтлан стандартад заасан жорын маягтад эсвэл цахимаар бичнэ.~~

6.1 Эмчлэх эрх бүхий хүний их эмч энгийн, сэтгэцэд нөлөөт, мансууруулах болон эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй олгох эмийн жорыг, бага эмч энгийн эмийн жорыг тус тус энэхүү стандартыг баримтлан цахимаар бичнэ.

6.1.1 Сэтгэцэд нөлөөт эмийг цахимаар болон энэхүү стандартын 5.7-д заасан маягтыг ашиглан хамт бичиж цахим жорын кодыг олгоно. эмчийн гарын үсгийн дээд талд бичнэ.

6.1.2 Мансууруулах эмийг цахимаар бичих ба тус стандартын 5.10-д заасан маягтыг ашиглан хамт бичиж цахим жорын кодыг олгоно.

6.1.3 Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нарийн мэргэжлийн эмчийн тогтоосон оношийг үндэслэн өвчтөний харьяалагдах өрх, сумын их эмч, эмчлэх эрх бүхий багийн хүний бага эмч мансууруулах эмийг цахимаар болон стандартад заасан жорын маягтад бичиж болно.

6.1.4 Хөдөө орон нутгийн өвчтөн нарийн мэргэжлийн эмчийн хяналтан дор эмчлүүлж буй тохиолдолд эмчийн тогтоосон оношийг үндэслэн түр оршин суух хорооны өрхийн эмч мансууруулах эмийн жорыг цахимаар болон стандартын шаардлага хангасан жоронд бичиж болно.

~~6.2 Цахим жор бичих зарчим, журмыг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу цахим жорыг (мансууруулах эмэнд хамаарахгүй) бичнэ.~~

6.3 Эмч жор бичихдээ улсын бүртгэлд бүртгэгдсэн эмийг олон улсын (Genetic) нэршлээр, Латин хэл дээр бичнэ.

6.4 Улсын бүртгэлд бүртгэгдсэн, жороор олгох эмийн мэдээллийг <https://mmra.gov.mn> цахим хуудасны шууд холбоос болох “Эмийн бүртгэл Licemed” программаас авна.

6.5 Эмийн хэлбэрүүдийн жорыг дүрмийн дагуу, нийлмэл найрлагатай эмийн нэрийг жоронд бичихдээ худалдааны нэршлээр бичнэ. Өвчтөний нэрийг овгийн эхний үсгийн хамт, нас, хүйс оношийг (ICD) ангиллалын кодын хамт бүрэн бичих ба жорыг баллаж, засварлаж үл болно.

6.6 Эм бичих хэсгийн Rp: (Recipe) гэсэн тэмдэглэгээний ард эмийн нэр, тун хэмжээ, хэлбэрийг **Латин хэл** дээр бичнэ.

6.7 Хэрэглэх аргыг S: (Signa) гэсэн тэмдэглэгээний ард Монгол хэл дээр бичнэ.

6.8 Эмчилгээ үргэлжлэх хугацааг хоногоор тооцно.

6.9 Жорд шингэн эмийг мл ба дуслаар, бусад эмийн хэлбэрийн тунг грамм (г), миллиграмм (мг), микрограмм (мкг), олон улсын нэгж (ОУН)-ээр илэрхийлж бичнэ.

6.10 Нийлмэл найрлагатай эмийн жорыг бичихдээ худалдааны нэршлээр латинаар бичнэ.

6.11 Эмийн санд найруулж бэлтгэх эмийн жорыг бичихдээ эхлээд гол үйлдэл үзүүлэх эмийн бодисыг, дараа нь туслах чанарын эмийн бодис, үүний дараа эмийн амт үнэр, өнгийг засах хольц бодис, хамгийн сүүлд эмийн хэлбэр оруулах бодисын нэрийг латинаар бичиж, тунг тодорхой зааж, дэс дараатай бичиж, хэрэглэх аргыг заана.

6.12 Энгийн эмийн жорын маягтад 3-аас илүүгүй, сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтад 2-оос илүүгүй, мансууруулах эмийн жорын маягтад 1 эм бичнэ.

6.13 Сэтгэцэд нөлөөт эмийг сэтгэцийн өвчний оношийн дагуу өвчтөний биеийн байдлыг харгалзан 10 хүртэлх хоногийн хэрэгцээнээс илүүгүй бичнэ.

6.14 Хөнгөвчлөх эмчилгээнээс бусад тохиолдолд мансууруулах эмийн жорын маягтад дараах эмийн хэлбэрүүдийн аль нэгийг 3 хоногийн хэрэглээнээс илүүгүйгээр бичнэ. Үүнд: үрэл, шахмал, лаа, туншил, шингэн.

6.15 Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдсан өвчтөнд мансууруулах эмийг тухайн өвчтөний биеийн байдлыг харгалзан 10 хүртэлх хоногийн хэрэгцээнээс илүүгүй бичнэ.

6.16 Жорын маягтад бичигдсэн эмийн хооронд тусгаарлах тэмдэг (#) тавина.

6.18 Цахим хэлбэрээр бичсэн энгийн эмийн жорыг иргэний хүсэлтийн дагуу жорын маягт дээр бичиж өгч болох ба цахим жорын кодыг олгоно

6.17 Эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй олгох эм болон энгийн эмийн жорыг цахимаар болон жорын маягт дээр бичихдээ эмчийн гарын үсэг, тэмдэг дарж баталгаажуулна

6.18 Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жорыг цахимаар болон жорын маягт дээр бичихдээ эмчийн гарын үсэг, тэмдэг, ерөнхий эмчийн гарын үсэг, эмнэлгийн тэмдэг дарж баталгаажуулна.

~~6.17 Энгийн эмийн жорыг эмчийн тэмдгээр, эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй олгох эмийг энгийн эмийн жорын маягт дээр эмчийн болон эмнэлгийн тэмдгээр, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жорыг эмчийн тэмдэг, ерөнхий эмчийн гарын үсэг, дарж баталгаажуулна~~

6.19 Эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй олгох эмийн жорыг энгийн эмийн жорын маягтад энэхүү стандартад заасны дагуу бичих ба энгийн эмийг 6.12, сэтгэцэд нөлөөт эмийг 6.13, мансууруулах эмийг 6.14, 6.15 заалтад заасан тоо хэмжээгээр бичнэ.

6.20 Жор бичигдсэн өдрөөс хойш 7 хүртэлх хоногийн хугацаанд хүчинтэй.

6.21 Урт хугацаанд эмчийн хяналтанд уух эмийн жорыг 3 сар хүртэлх хугацаагаар бичнэ.

6.22 Гадаад улсад 3 сараас дээш хугацаан зорчих нь нотлогдсон тохиолдолд урт хугацаанд уух эмийн жорыг бичихдээ тун хэмжээ, тоо ширхгийн дагуу хамгийн ихдээ 6 сарын түрш хэрэглэхээр бичиж болно.

6.23 Жор бичигч нь 0-16 насны хүүхдийн жор бичихдээ асран хамгаалалгчийн хурууны хээгээр баталгаажуулна.

7 Эм олгох

7.1 Жор баригч улсын бүртгэлд бүртгэгдсэн эмийг эмчийн бичсэн жорын дагуу өвчтөнд олгохдоо эмийн нэр, тун хэмжээг 3 удаа давтан уншиж, иргэнд үлдэх хэсэгт эмчийн бичсэн жорын дагуу эмийн нэр, тун хэмжээ, хэлбэр, хэрэглэх арга, хугацааг тэмдэглэж, эмийн хамт олгох ба эмийг хэрэглэх явцад илэрч болох гаж нөлөөний талаар мэдээллийг заавал хэлж өгнө.

~~7.2 Улсын бүртгэлд бүртгэгдсэн, жороор олгох эмийн мэдээллийг <https://mmra.gov.mn> цахим хуудасны шууд холбоос болох “Эмийн бүртгэл Licemed” программаас авна.~~

7.3 Жороор олгох эмийг жоргүй олгохыг хориглоно.

7.4 Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтын ар талд эм хүлээн авсан хүний нэр, хаяг, регистрийн дугаар, утасны дугаар, огноог тэмдэглэж, гарын үсэг зуруулж, эм зүйч хянаж баталгаажуулна.

7.5 Жор баригч жорыг хүлээн авч, тохирох бүртгэлийг холбогдох стандарт, журамд заасны дагуу хөтөлнө.

7.6 Жорд бичсэн эмийг найруулж буюу дахин савлаж олгоход эмийн хаяглалт дараах мэдээллийг агуулсан байна.Үүнд:

- ☐ Өвчтөний нэр;
- ☐ Эмийн нэр;
- ☐ Тун, тоо хэмжээ;
- ☐ Хэрэглэх арга, хугацаа;
- ☐ Эмийн хүчинтэй хугацаа;
- ☐ Цувралын дугаар;

□ Хадгалах нөхцөл.

8. Эмийн жор бичилт, олголт, түүнд хяналт, зохицуулалт хийх байгууллагын эрх, үүрэг

8.1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага

8.1.1 Энэхүү зааврыг мөрдөх эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь цахим жор бичигч болон иргэний мэдээллийг баталгаажуулах хүрууны хээ уншигч төхөөрөмжтэй мөн интернет сүлжээнд холбогдсон байна.

8.1.2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь цахим жор бичигчид цахим жорын системд нэвтрэх эрхийг олгох, хаах, сэргээх, шилжүүлэх, цуцлах зэрэг зохицуулалтыг хариуцах админтай байна.

8.1.3 Эмнэлгийн удирдлага цахим жорын системд нэвтрэхэд эрх олгосон эмчийг эрхээ бусдад дамжуулан ашиглуулахгүй, зүй бусаар ашиглахгүй, хувь хүний нүүцыг задруулахгүй байхад хяналт тавьж, хариуцлага хүлээнэ.

8.1.4 Энэхүү стандартын 5.6 заалтад заасны дагуу жорын маягтыг хэвлүүлж, эмч мэргэжилтнүүдэд түгээнэ,

8.2 Эмийн сан

8.2.1 Эмийн сан цахим жороор үйлчлэхдээ Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:20... стандартыг баримтална.

8.2.2 Эмийн сангийн жор баригч иргэний амбулаториор үйлчлүүлэгчдийн карт дахь хяналтын дугаар эсвэл регистрийн дугаарыг үндэслэн иргэний үнэмлэхтэй тулган баталгаажуулж эмийг олгоно.

8.2.3 Иргэнд эмийг олгохдоо эмийн нэр, түн хэлбэр, тоо хэмжээг цахим жорын системийн мэдээллийн дагуу олгоно.

8.2.4 Үзлэг хийлгэж жор бичүүлсэн иргэн өөрөө ирээгүй тохиолдолд иргэний үнэмлэхийг үндэслэн жорыг олгож болно.

8.3 Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

8.3.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэхээр батлагдсан эмийн жагсаалтын дагуу санхүүжилтийг тооцох үйл ажиллагааг зохион байгуулна.

8.3.2 Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь Админ болон тухайн эрүүл мэндийн байгууллагын даргатай "Хэрэглэгчийн нууцлал, аюулгүй байдлын гэрээ" байгуулж, цахим жорын системд нэвтрэх зохицуулалтыг хариуцах Админ эрхийг олгоно.

8.3.3 Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалтыг шинэчлэн батлагдах тухай бүрд эмийн нэр, үнэ, хөнгөлөлтийн хувь хэмжээг цахим жорын системд шинэчлэн оруулна.

8.3.4 Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь хөнгөлөлттэй эм олгох үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтыг ЭМД-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.7 дахь заалтыг үндэслэн хийнэ.

8.4 Эрүүл мэндийн хөгжлийн төв

8.4.1 Цахим жорын системийн тогтвортой үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар

8.4.2 Эрүүл мэндийн салбарын байгууллагуудыг цахим жорын систем ашиглах арга зүйгээр хангана

8.5 Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар

8.5.1 Цахим жорын систем хэрэглэх талаарх сургалт зохион байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангана.

8.5.2 Энэхүү стандартын 5.7, 5.10 заалтад заасны дагуу хэвлүүлж, эрүүл мэндийн байгууллагуудад түгээнэ.

8.6 Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар

8.6.1 Эмийн бүртгэлийн Licemed” цахим мэдээллийн сангийн үйл ажиллагаа, үнэн, зөв бодит байдлыг хангана

8.6.2 Цахим жорын системээс эмийн бүртгэл, статистикийн үзүүлэлтийг гаргана.

8.6.3.Эмийн жор бичилт олголтод хяналт тавих, арга зүйгээр хангах

8.6.4 Цахим жороор олгогдсон эмийн мэдээллийг харах, дүн шинжилгээ хийх

9 Жорын маягтыг хадгалах, тайлагнах

~~9.1 Жор баригч иргэдээс хүлээн авсан жорын бүртгэлийг сар, улирлаар нэгтгэн, хөлбөгдөх стандарт, журамд заасны дагуу дүгнэнэ.~~

9.2 Энгийн эмийн жорыг 1 жил, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жорыг 2 жил хадгална.

9.3 Энгийн эмийн жорын маягтан дээр бичигдсэн Эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлттэй олгох эмийн жорын тооцоог даатгалын байгууллагатай хийнэ.

9.4 Мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийн жорын маягтан дээр бичигдсэн эмийн жорын тооцоог Цагдаагийн ерөнхий газартай хийнэ.